



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль 9 дүгээр зүйлийн 9.1, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ны 2.1.2, 2.1.3, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, байнгын хадгалалтад баримт шилжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагын “Баримт нягтлан шалгах комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Комиссын дарга:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Комиссын гишүүд:	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Бодлогын баримт бичгийн тайлан, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Байгууллагын комиссыг нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Баримт нягтлан шалгах комисс (Х.Содномдэмбэрэл)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын “Баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай” 2019 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А/61 дүгээр тушаалыг хүчингүй болгонд тооцсугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

1150500028